



ГОВЬСҮМБЭР АЙМАГ  
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 07 сарын 24 өдөр

Дугаар А/134

Шивээговь сум

Газар эзэмшүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1.3, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4.3 дахь заалт, 31 дүгээр зүйлийн 31.2, 33 дугаар зүйлийн 33.1.1, Засгийн газрын 2001 оны 263 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт “Эрчим хүчний шугам сүлжээг хамгаалах дүрэм”, сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2021 оны 07 дугаар сарын 21-ний өдрийн 04 дугаар “Сумын Газар зохион байгуулалтын 2021 оны төлөвлөгөөнд нэмэлтээр газар тусгах тухай” тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Сумын 2 дугаар багийн нутаг дэвсгэрээр дайран өнгөрөх 25,86 км газрыг 220 Кв-ийн “Агаарын шугам” барих зориулалтаар Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ Төрийн өмчит хувьцаат компанид 15 жилийн хугацаатай эзэмшүүлсүгэй.

2. Монгол Улсын Газрын тухай хууль, Газрын төлбөрийн тухай хуулийг дагаж мөрдөхийг газар эзэмшигч Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ Төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал (Б.Нямсамбуу)-д үүрэг болгосугай.

3. Газар эзэмшигч Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ Төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Б.Нямсамбуутай газар эзэмших гэрээ байгуулж, гэрчилгээ олгон хууль тогтоомжийн дагуу хяналт тавьж ажиллахыг Газрын даамал (Э.Баярмагнай)-д даалгасугай.

4. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2020 оны 07 дугаар сарын 29-ний өдрийн А/134 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



П.ГАНЧИМЭГ